тэтгэмжийн даатгалын санд дараа сарын зарлагын 100 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөөцтэй байх"-аар зохицуулсантай холбоотой байна. Мөн Засгийн газрын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 239, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээ, шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолын дагуу цалингийн хэмжээ өссөнтэй холбоотой байгууллагуудын цалингийн сан өсөж, түүнийг дагаад нийгмийн даатгалын шимтгэл өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдэл 81,054,353.5 мянган төгрөг болж, 3,782,123.6 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс санхүүжих авлагын үлдэгдэл 11,371,624.0 мянган төгрөгөөр буурч, төлбөртэй үйлчилгээний авлага цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой аж ахуй нэгж байгууллага, иргэдээс авах НДШ-ийн авлага 7,589,727.6 мянган төгрөгөөр өссөн нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,730.7 мянган төгрөг болж 5,898.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор худалдан авсан бичиг хэргийн, аж ахуйн материалын худалдан авалт өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,425,005.3 мянган төгрөг болж 72,533.0 мянган төгрөгөөр буурсан нь НИТХ-ын 92 дугаар тогтоол, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ийн А/103 тушаал, НДЕГ-ын А/186, А/200 дугаар тушаалыг үндэслэн 17,341.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр нэмж бүртгэн, НДЕГ-ын даргын А/200 дугаар тушаалаар 2 нэр төрлийн 100 ширхэг, 4,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацааны элэгдлийг зардлыг тооцож бүртгэсэн нь хөрөнгийн бууралтад нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,070,501.0 мянган төгрөг болж, 2,694,793.3 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 239, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийн дагуу хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн өглөг 51,753.8 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжийн өглөг 3,484.5 мянган төгрөг, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн өглөг 291,259.0 мянган төгрөг, өндөр насны тэтгэврийн өглөг 25,400.9 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэврийн өглөг 9,949.4 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийн өглөг, 2,369.3 мянган төгрөг, ҮОМШӨ-ний ХЧТА тэтгэмж болон рашаан сувиллын өглөг 2,986.8 мянган төгрөг, цэргийн алба хаасны тэтгэврийн өглөг болон цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэврийн өглөг 1,010.1 мянган төгрөг, улсын төсвөөс санхүүжих тэтгэврийн өглөг 394.3 мянган төгрөг, бусад өглөг 184,104.6 мянган төгрөг, нийт 572,712.8 мянган төгрөгийн өглөг, урьдчилж төлсөн НДШ-ийн орлого, ЭМД орлого, нөхөн шимтгэлийн орлого, урьдчилж төлсөн сайн дурын даатгуулагч эхийн өөрөө төлсөн болон тэтгэмжийн даатгалын санд төлсөн НДШ, урьдчилж төлсөн тэтгэврийн төсвийн санхүүжилт, урьдчилж төлсөн НДШ-үүд нийт 3,497,788.1 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

Засгийн газрын хувь оролцоо /цэвэр хөрөнгө/ дансны үлдэгдэл 11,158,177.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант хугацаанд тус байгууллагын төсөвт НДЕГ-ын даргын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн А/105 дугаар тушаалаар тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн даатгалын хөтөлбөрийн 9 арга хэмжээний зардлыг 437,037,322.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөв баталснаас, 435,067,144.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардалд, 1,970,177.9 мянган төгрөгийг хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардалд тус тус зарцуулахаар төсөвлөж баталсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 324,096,428.0 мянган төгрөгийн, улсын төсвөөс 99,713,501.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 549,152.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 432,165,700.2 мянган төгрөг зарцуулж, 48,136,326.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 432,165,700.2 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4,871,622.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,935,421.8 | 1,882,423.1 | 52,998.7 | 97.3 |
| 2 | 80820 Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,331.0 | 11,781.7 | 549.4 | 95.5 |
| | **Дүн** | **1,947,752.8** | **1,894,204.7** | **53,548.1** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Мөнхжаргал, аудиторын туслах Э.Билгүүн нар гүйцэтгэж, хяналтыг ХХК-ийн аудитын менежер Т.Болортуяа, захирал С.Бадамгарав, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 116,799,045.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 583,995.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 408,796.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг 40,995.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,730.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 2,814.2 мянган төгрөг, томилолт зочдын зардлыг 3,501.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 10,344.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулж нийт 60,385.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 107 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2023 оны эхний хагас жилийн завсар үеийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 925,596.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгснийг тус тус 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 4 | 925,596.4 | 4 | 925,596.4 | 100 |
| Зөвлөмж | 5 | 5,069.1 | 5 | 5,069.1 | 100 |
| **Нийт дүн** | **9** | **930,665.5** | **9** | **930,665.5** | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ТЕЗ-ийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулахыг уламжилж байна. Үүнд:

- НДШ-ийн авлагын эхний үлдэгдлээс ЭМД-ын авлагыг салгаж хасалт хийж шилжүүлээгүй байна.
- НББББББ ба сан, үйл ажиллагааны зардлын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нийцлийг үзэх зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,083,494.1 мянган төгрөгийн зөрчилд[1] 3 албан шаардлага хүргүүлэв.

### 5.1 Албан шаардлага

- Аж ахуй нэгж байгууллагаас авах 139,837.3 мянган төгрөгийн акт төлбөрийн авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.
- Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах НДШ-ийн 8,677,667.3 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.
- Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах 265,989.3 мянган төгрөгийн бусад авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

*Шийдвэрлэсэн:* Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аж ахуй нэгж байгууллагаас авах 139,837.3 мянган төгрөгийн акт төлбөрийн авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй | 1 | 139,837.3 | | | 1 | 139,837.3 | | | | | - | - |
| 2 | Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах НДШ-ийн 8,677,667.3 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй | 1 | 8,677,667.4 | | | 1 | 8,677,667.4 | 1 | - | | | | |
| 3 | Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах 265,989.3 мянган төгрөгийн бусад авлагыг тайлант онд барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй | 1 | 265,989.4 | | | 1 | 265,989.4 | | | | | | |
| Дүн | | 3 | 9,083,494.1 | - | - | 3 | 9,083,494.1 | - | - | - | - | - | - |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ: /С.БАДАМГАРАВ/ Огноо: 2024.02.23

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР: /Т.БОЛОРТУЯА/ Огноо: 2024.02.23

БОЛОВСРУУЛСАН:

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР /Д.МӨНХЖАРГАЛ/ Огноо: 2024.02.23.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 445

танай ______________-ны №______________-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС, САНГИЙН ДАРГА Ш.АРИУНТУЯА ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", СТОУС 9-ийн 5-ын 5.2 зүйл: "аж ахуй нэгж нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд болон бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг мөрдөнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"* заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Тайлант оны эхний үлдэгдэл 9,083.5 сая төгрөгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагад хөдөлгөөн гараагүй, авлага бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үндэслэн сайн дурын даатгал төлсөн иргэд, аж ахуйн

нэгж байгууллагын төлсөн шимтгэлийг холбогдох даатгалын сангийн өглөгөөр биш сангийн орлогоор бүртгэсэн байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй, нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.02.23.BZD.NDH.docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.02.23 № 448

танай ________-ны № ________ -т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС, САНГИЙН ДАРГА Ш.АРИУНТУЯА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн зөрчилд тогтоосон 9,083,494.0 мянган төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002033286

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.02.23.BZD.NDH.Ash.A5.docx

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 112/ 20110572 Улаанбаатар хот

НТАГ- 2024/3801 НА-СТА - Тай

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн нэгж байгууллагаас авах 139,837,317.74 (Нэг зуун гучин есөн сая, найман зуун гучин долоон мянга, гурван зуун арван долоон төгрөг, далан дөрвөн мөнгө) төгрөгийн актын төлбөрийн авлагад хөдөлгөөн гараагүй, авлага бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй нь УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын* 4.2.1.*"албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.11.*"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Аж ахуйн нэгж байгууллагаас авах актын төлбөрийн авлагад тайлант онд хөдөлгөөн гараагүй, авлага бууруулах арга хэмжээ авч ажиллагаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн дарга Ш.Ариунтуяа, нягтлан бодогч О.Сайнзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.БАДАМГАРАВ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633

УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042702

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 113/2011057 Улаанбаатар хот
НТАГ-2023/380/НА-СТА-Тмс

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хүрээнд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах 8,677,667,394.84 (найман тэрбум зургаан зуун далан долоон сая, зургаан зуун жаран долоон мянга, гурван зуун ерэн дөрвөн төгрөг, наян дөрвөн мөнгө) төгрөгийн НДШ-ийн авлагад хөдөлгөөн гараагүй, авлага бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй нь УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын* 4.2.1.*"албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.11.*"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах НДШ-ийн авлага бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн дарга Ш.Ариунтуяа, нягтлан бодогч О.Сайнзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.БАДАМГАРАВ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042703

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 115/20110572 Улаанбаатар хот

НТАГ-2024/380/НА-СТА-Тees

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах 265,989,381.00 (хоёр зуун жаран таван сая есөн зуун наян есөн мянга гурван зуун наян нэг) төгрөгийн бусад авлагад хөдөлгөөн гараагүй, авлага бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй нь УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын* 4.2.16.*"албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.11.*"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах бусад авлагыг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн дарга Ш.Ариунтуяа, нягтлан бодогч О.Сайнзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.БАДАМГАРАВ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042717